



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Уул сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДОА-2022/18/НА/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2022 он	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: И.Сэмжидмаа Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Нармандах Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



БАЯН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Л.БЯМБАДОРЖ ТАНАА

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2022.02.08 № 22

танай _____-ны № _____-т

Г _____ 7

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Уул сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Уул сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ

011020767

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/сая төгрөгөөр/

	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	94.2	93.3
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	6,178.4	5,880.5
	Нийт хөрөнгийн дүн	6,272.5	5,973.8
	Нийт өр төлбөрийн дүн	-	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,272.5	5,973.8
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,272.5	5,973.8
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	5,668.0	847.3
	Үйл ажиллагааны зардлын дүн	620.5	948.5
	Үйл ажиллагааны үр дүн	5,047.4	(101.1)
	Үйл ажиллагааны бус үр дүн	4,000.0	197.6
	Үйл ажиллагааны нийт үр дүн	1,047.4	(298.8)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,225.1	6,272.5
	Тайлант оны үр дүн	1,047.4	(298.8)
	Эцсийн үлдэгдэл	6,272.5	5,973.8
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	606.9	584.6
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	501.4	560.5
	Үйл ажиллагааны ЦМГ	105.4	24.1
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(105.4)	(24.1)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	(0.0)	0.0
	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	606.9	581.6
	Урсгал зардал	501.4	560.5
	Хөрөнгийн зардал	105.4	21.1
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	467.1	570.8
	Улсын төсвөөс санхүүжих	466.5	570.2
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	0.6	0.6

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл нь нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах, иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Бараа материалын дансанд бүртгэлтэй малын тооллого хийсэн бүртгэл, тайлан байхгүй, зөвхөн А дансыг үндэслэн бүртгэл тайланд тусгасан байна.

Дөрөв. Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ, үйл явдал гараагүй байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Баян-Уул сумын ЗДТГ нь 2021 онд нийт 504.2 сая төгрөгийн 15 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц чухал асуудал гараагүй.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар 24.1 сая төгрөгийн хөрөнгийг тооцооны дансаар дамжуулан залруулж, ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолыг зөрчиж зарцуулсан 1.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, бараа материалын дансанд бүртгэлтэй 53.2 сая төгрөгийн малын тооллого хийсэн бүртгэл, тайлан байхгүй, зөвхөн А дансыг үндэслэн бүртгэл тайланд тусгасан зөрчилд зөвлөмж өгсөн.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1	-	-	1	-	-	-
	НИЙТ	1	1	-	-	1	-	-	-

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	79.0	3	1	24.1	1	1.7	-	-	1	53,2
	НИЙТ	79.0	3	1	24.1	1	1.7	-	-	1	53.2